



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

“Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ыг батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.2, Улсын Их Хурлын 2013 оны 41 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг батлах тухай 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000065

**ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР
МЭРГЭШЛИЙН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ,
МЭРГЭЖИЛТЭНД ЭРХ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ** А0410 5043239

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэргэшлийн сургалт, шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэшлийн зөвлөлөөс өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. “зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах мэргэжилтэн” /цаашид мэргэжилтэн гэх/ гэж Үнэт цаасны зах зээлийн тухайн хуулийн 35.1-д заасан эрх авсан этгээдийг;

1.2.2. “үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос олгох эрхийг;

1.2.2. “мэргэшлийн зөвлөл” гэж үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтний ажил, үйлчилгээ явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг;

1.2.3. “сургалт зохион байгуулагч” гэж Үнэт цаасны зах зээлийн 69.2-т заасан чиг үүрэг бүхий мэргэжлийн холбоог;

1.2.4. “мэргэшлийн шалгалт” гэж зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах мэргэжилтэнд энэ журмын 2.1-д заасан чиглэлээр зохион байгуулсан сургалтын сэдэв агуулгыг судалж, эрхийг олгох шаардлага нөхцлийг хангасан эсэхийг тест болон ярилцлагаар баталгаажуулахыг.

Хоёр. Мэргэшлийн сургалтын чиглэл

2.1. Мэргэжилтэнд олгох эрхийг түүний эрхлэх ажил, үйлчилгээний төрөл, мэргэшлийн түвшингээс хамаарч дараах чиглэлээр олгоно.

2.1.1. Үнэт цаасны зуучлалын;

2.1.2. Хөрөнгө оруулалтын;

2.1.3. Үнэт цаасны арилжааны;

2.2. Мэргэжилтэн нь өөрийн эрхлэх ажил, үйлчилгээний төрлөөс хамаарч дор дурьдсан эрхийг авсан байна. Үүнд:

2.2.1. зохицуулалттай этгээдэд брокер, дилерийн ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтэн энэ журмын 2.1.1-д заасан эрхийг;

2.2.2. зохицуулалттай этгээдэд гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан болон хөрөнгө оруулалтын зөвлөх, санхүүгийн шинжээч, андеррайтер, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр ажил үйлчилгээ явуулах мэргэжилтэн энэ журмын 2.1.2-т заасан эрхийг;

2.2.3. үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, өмчлөх эрхийн бүртгэл, төвлөрсөн хадгаламж, кастодианы чиглэлээр ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтэн энэ журмын 2.1.3-т заасан эрхийг;

Гурав. Мэргэшлийн зөвлөл

3.1. Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах, мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийг Мэргэшлийн зөвлөл хэрэгжүүлнэ.

3.2. Мэргэшлийн зөвлөл нь орон тооны бус есөн гишүүдээс бүрдэнэ.

3.3. Мэргэшлийн зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг Хорооны дарга томилно.

3.4. Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны Үнэт цаасны газрын болон сургалт зохион байгуулагч, үнэт цаасны чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой багш судлаачдын төлөөлөл орж болох бөгөөд Мэргэшлийн зөвлөлийн дарга нь Хорооны гишүүн байна.

3.5. Мэргэшлийн зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.5.1. энэ журмын 2.1-д заасан чиглэлээр болон аттестатчилах шалгалтад тэнцсэн этгээдэд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох;

3.5.2. эрх олгох болон аттестатчилах шалгалтыг зохион байгуулах;

3.5.3. мэргэжлийн холбооноос боловсруулсан эрх олгох, аттестатчилах сургалтын жил бүрийн хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүн, мэргэшлийн шалгалтын хуваарийг батлах;

3.5.4. эрх олгох, аттестатчилах сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.5.5. эрх олгох, аттестатчилах шалгалтын тестийг боловсруулах, тестийн сан бүрдүүлэх;

3.5.6. сургалт зохион байгуулагчаас боловсруулсан сургалтын хуваарийг батлах;

3.5.7. шалгалтын тестийг бусдаар бөглүүлэх, шалгалт зохион байгуулж буй мэргэшлийн зөвлөлийн гишүүний зүй ёсны шаардлагыг биелүүлээгүй этгээдийг протоколд тэмдэглэж, шалгалтын тестийг хүчингүйд тооцох;

3.5.8. энэ журмын 8, 9 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.5.9. мэргэшлийн сургалт болон дахин шалгалтын төлбөрийн хэмжээг тогтоох.

3.6. Мэргэшлийн зөвлөлийн шийдвэр нь гишүүдийн дийлэнх олонхийн саналаар баталгаажна.

3.7. Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.7.1. мэргэшлийн зөвлөлийн хуралдааны болон тухайн шалгалтын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулах;

3.7.2. Хорооны цахим хуудсаар дамжуулан сургалт, шалгалтын товыг нийтэд мэдээлэх;

3.7.3. мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, нийтэд мэдээлэх;

3.7.4. мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Хорооны архивт дараа жилийн эхний улиралд багтаан шилжүүлэх.

3.8. Энэ журмын 6.11, 7.6-д заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд Мэргэшлийн зөвлөл мэдээллийн сангийн болон тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн хүчингүй тооцож, нөхөн олгоно.

3.9. Үнэт цаасны газрын Мэргэжлийн оролцогчдын хэлтсийн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн нь Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

Дөрөв. Шалгалт зохион байгуулах

4.1. Шалгалтын өмнөх өдөр Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон гишүүд тестийн сангаас шалгалтын тестийг боловсруулна.

4.2. Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон 3-аас доошгүй гишүүд шалгалтын тестийг хувилж, хувилбар тус бүрээр дугтуйлан битүүмжилнэ.

4.3. Тестийн битүүмжилсэн байдлыг нийт шалгуулагчдаар магадлуулснаар шалгалтын танхимд нээнэ.

4.4. Гадаад улсын иргэн шалгалтанд орчуулагчийн хамт оролцож болох бөгөөд энэ тохиолдолд тухайн гадаад иргэний шалгалтын үргэлжлэх хугацааг 10 минутаар сунгаж болно.

4.5. Шалгалт авах бэлтгэл ажлыг сургалт зохион байгуулагч хариуцах бөгөөд шалгалтын үеэр танхимд зөвхөн мэргэшлийн зөвлөлийн гишүүд байлцана.

4.6. Мэргэшлийн зөвлөл шалгалтыг зохион байгуулж, дүнг шалгуулагчдад танилцуулна.

Тав. Сургалт зохион байгуулах

5.1. Сургалт зохион байгуулагч нь сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Мэргэшлийн зөвлөлөөр батлуулан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70.1.2-д заасны дагуу дор дурьдсан мэргэжлийн сургалтыг зохион байгуулна. Үүнд:

5.1.1. мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалт;

5.1.2. аттестатчилах үргэлжилсэн багц цагийн сургалт;

5.2. Сургалт зохион байгуулагч нь энэ журмын 5.1-д заасны дагуу сургалтын жилийн хөтөлбөр, шалгалтын хуваарийг Мэргэшлийн зөвлөлөөр батлуулан олон нийтэд мэдээлнэ.

5.3. Сургалтад хамрагдах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.3.1. бакалавраас доошгүй зэрэгтэй байх;

5.3.2. сүүлийн 3 жилийн хугацаанд хууль тогтоомж зөрчсөний улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаал эрхлээгүй;

5.3.3. сургалтын төлбөрийг бүрэн төлсөн байх.

5.4. Сургалтад хамрагдах этгээд нь энэ журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу өргөдөл, анкетыг бөглөж, 5.3.-т заасан шаардлагыг хангасан тухай баримтын бүрдлийг сургалт зохион байгуулагчид ирүүлнэ.

5.5. Энэхүү журмын 2.1.1-д заасан чиглэлээр 45-аас доошгүй, 2.1.2, 2.1.3-д заасан чиглэлээр эрх олгох сургалтууд тус тус нийт 70-аас доошгүй нэгж цаг байх бөгөөд нэгж цаг нь 45 минуттай тэнцэхүйц, үнэт цаасны зах зээлтэй холбоотой эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт, эрсдлийн удирдлага, эрх зүйн зохицуулалтын сэдэв, агуулгатай байна.

5.6. Сургалтыг хичээлийн танхим, техник, тоног төхөөрөмжийн шаардлага хангасан,

сургалтын материалыг сургалтад хамрагдагч бүрт хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

5.7. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй эсхүл сургалтад суухгүйгээр шалгалтад орох боломжтой гэж үзсэн этгээд нь сургалтад хамрагдахгүйгээр шалгалтад орох өргөдлийг Мэргэшлийн зөвлөлд гаргана. Энэ тохиолдолд уг этгээд нь мэргэшлийн сургалтын төлбөрийг бүрэн төлсөн байна.

Зургаа. Мэргэжилтэнд эрх олгох

6.1. Энэхүү журмын 2.1-д заасан сургалт тус бүрээр 80 хувиас доошгүй цагийн сургалтыг хангасан этгээдээс үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалт авна.

6.2. Шалгалт нь тест болон ярилцлага гэсэн 2 үе шаттай байна. Шалгалтын агуулга, тестийн асуултын тоо, үргэлжлэх хугацааг Мэргэшлийн зөвлөл тогтооно.

6.3. Шалгалтын цаг дууссаны дараагаар хариултын хуудсыг шалгуулагчдын өмнө тусгай төхөрөөмжөөр уншуулан жагсаалтаар дүнг гаргаж, танилцуулан Мэргэшлийн зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар баталгаажна.

6.4. Жагсаалтаар гарсан дүнг өөрчлөх буюу засахыг хориглоно.

6.5. Мэргэшлийн зөвлөл нь шалгалт өгсөн этгээдийн хүсэлтээр түүний шалгалтын материалтай танилцах боломжоор хангана.

6.6. Тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг зөв хариулсан этгээд нь шалгалтын дараагийн үе шат буюу ярилцлагад орох эрхтэй. Ярилцлага 5 асуулттай байх бөгөөд түүнээс 60-аас дээш хувийг зөв хариулсан этгээдийг Мэргэшлийн зөвлөл шалгалтад тэнцсэнд тооцно.

6.7. Мэргэшлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг чиглэл тус бүрээр 3 жилийн хугацаатайгаар Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрээр олгоно.

6.8. Энэ журмын 2.1.2-д заасан чиглэлээр эрх авсан этгээд нь брокер, дилерийн эрхийг мөн адил эдэлнэ.

6.9. Тестийн шалгалтанд тэнцээгүй этгээдээс дахин шалгалтыг нэг удаа авах бөгөөд дахин шалгалтын товыг Мэргэшлийн зөвлөл эхний шалгалт авах өдөр тогтооно.

6.10. Дахин шалгалтад хамрагдах өргөдлөө тухайн шалгалт авах өдрөөс ажлын 3 хоногийн өмнө сургалт зохион байгуулагчид гаргана. Өргөдөл гаргаагүй тохиолдолд дахин шалгалтад хамруулахгүй.

6.11. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан этгээдэд энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу Мэргэшлийн зөвлөл гэрчилгээ олгоно.

Долоо. Мэргэжилтэнг аттестатчилах

7.1. Мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн хүчинтэй байх хугацаанд жил бүр зохион байгуулагдах аттестатчилах багц цагийн сургалтад хамрагдах үүрэгтэй. Мэргэшлийн зөвлөл нь аттестатчилах сургалтын багц цагийг нөхөх, дүйцүүлэн тооцож болохуйц бусад сургалтыг тогтоож болно.

7.2. Энэ журмын 7.1-д заасан шаардлагыг хангасан мэргэжилтэн аттестатчилалд хамрагдах өргөдлийг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу эрх нь дуусгавар болохоос нэг сарын өмнө сургалт зохион байгуулагчид гаргана.

7.3. Сургалт зохион байгуулагч аттестатчилалд хамрагдах өргөдөл гаргагчдын нэгдсэн жагсаалтыг гаргаж, Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

7.4. Аттестатчилах шалгалтыг энэ журмын 6 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

7.5. Мэргэшлийн зөвлөл мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг аттестатчилах шалгалт өгч тэнцсэн тохиолдолд дөрвөн жилээр, хоёр дахь удаад зургаан жилээр сунгах, гурав дахь удаа аттестатчилах шалгалтад тэнцсэн тохиолдолд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг хугацаагүйгээр олгоно.

7.6. Аттестатчилах шалгалтад тэнцсэн этгээдэд энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гэрчилгээ олгоно.

7.7. Аттестатчилах шалгалтад тэнцээгүй эсхүл энэ журмын 6.1-д заасан шаардлагыг хангаагүйгээс шалгалтанд хамрагдаагүй мэргэжилтний эрхийг хүчингүй болгох асуудлыг сургалт зохион байгуулагч Мэргэшлийн зөвлөлд гаргана.

7.8. Сургалт зохион байгуулагч нь дараах үндэслэлээр мэргэжилтнийг хугацаанаас өмнө дахин аттестатчилалд орохыг шаардана. Үүнд:

7.8.1. үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдээс дахин шалгалтад оруулах үндэслэл бүхий хүсэлт гаргасан;

7.8.2. тухайн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, ёс зүйн асуудлаар холбогдуулж харилцагчаас Хороонд хандаж гаргасан гомдол нотлогдсон;

7.8.3. тухайн мэргэжилтэнг мэргэжлийн холбооны ёс зүйн хорооноос дахин аттестатчилах шаардлагатай гэж дүгнэсэн.

Найм. Мэргэжилтний эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай

8.1. Мэргэшлийн зөвлөл нь дараах үндэслэлээр мэргэжилтний эрхийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

8.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн;

8.1.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын тухайн мэргэжилтний ёс зүйн алдаа гаргасан талаарх үндэслэл бүхий дүгнэлт;

8.1.3. энэ журмын 7.1-д заасан шаардлагыг хангаагүй.

8.2. Мэргэшлийн зөвлөл нь дараах үндэслэлээр мэргэжилтний эрхийг хүчингүй болгоно. Үүнд:

8.2.1. Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн;

8.2.2. түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй;

8.2.3. эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон.

8.3. Мэргэжилтний эрхийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон тухай шийдвэрийг Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлын 10 хоногт багтаан Хорооны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

8.4. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг Мэргэшлийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

Ес. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

9.1. Мэргэжилтний эрх олгох болон аттестатчилах мэргэшлийн сургалт, шалгалттай холбоотой өргөдлийг Мэргэшлийн зөвлөл хүлээн авч, шийдвэрлэнэ.

9.2. Шалгуулагч шалгалтын дүнтэй санал нийлэхгүй, шалгалтын тесттэй холбоотой өргөдлийг шалгалтын дүн зарлагдсанаас хойш ажлын гурван хоногт багтаан Мэргэшлийн зөвлөлийн даргад бичгээр ирүүлнэ.

9.3. Мэргэшлийн зөвлөл өргөдлийг ажлын гурван өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид бичгээр хүргүүлнэ.

9.4. Шалгалтын дүнтэй холбогдсон маргаан гарвал Мэргэшлийн зөвлөлийн дарга магадлах ажлын хэсгийг томилон, материалыг дахин шалгуулах эрхтэй бөгөөд тухайн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Мэргэшлийн зөвлөл шийдвэр гаргана.

9.5. Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Хорооны даргад гомдол гаргах эрхтэй.

ooOo

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны ... дүгээр тогтоолоор батлагдсан
“Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох тухай эсурам”-ын 1 дүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ, ШАЛГАЛТАД ОРУУЛАХЫГ ХҮССЭН
ӨРГӨДӨЛ

Огноо :
Хаана: Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мэргэшлийн зөвлөл
Засгийн газрын IV байр
Бага тойруу -6
Улаанбаатар -210646
Монгол улс
Хэнээс: овогтой

Миний бие үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох сургалт,
шалгалтад оролцохоор хүсэлт гаргаж байна.

Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад
оролцохоор бүрдүүлж хүргүүлсэн бичиг баримтуудыг үнэн зөв бүрдүүлсэн болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянаж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн
ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад оролцуулна уу.

Миний бие цаашид “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох
хууль тогтоомж, журам зааврыг мөрдлөг болгож, мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн ажиллах
болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны ... дүгээр тогтоолоор батлагдсан
 “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх,
 хүчингүй болгох тухай журам”-ын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖИЛТНИЙ АНКЕТ

Регистрийн дугаар			
Овог нэр			Төрсөн огноо
ОДООГИЙН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ			
Байгууллагын нэр			
Албан тушаал			
Ажлын болон гар утас			
Е-мэйл хаяг			
ӨМНӨ НЬ ЭРХЭЛЖ БАЙСАН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ			
Байгууллагын нэр			
Албан тушаал			
Ажилласан хугацааоноос....он хүртэлоноос....он хүртэлоноос....он хүртэл
БОЛОВСРОЛЫН ТУХАЙ			
Төгссөн сургуулийн нэр			
Эзэмшсэн мэргэжил			
Эрдмийн зэрэг цол			
ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ			
Овог нэр	Таны юу болох	Төрсөн он	Одоо эрхэлж байгаа ажил/ сургууль

Дээрх мэдээллийг үнэн зөв бичсэн /гарын үсэг/

201 оны сарын ... өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны ... дүгээр тогтоолоор
батлагдсан “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд
эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ын
3 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛ

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...

... оны ... сарын ... өдөр

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35, 69 дүгээр зүйл, Хорооны 2014 оны сарын өдрийн дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ын шаардлагыг хангаж, мэргэшлийн шалгалтад тэнцсэн тул овогтой -нд /РД / чиглэлээр 20....онысарын-ны өдрөөс 20....онысарын-ны өдрийг хүртэл Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг 3 жилийн хугацаагаар олгов.

ДАРГА

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны ... дүгээр тогтоолоор батлагдсан
“Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох тухай журам”-ын 4 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛ

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...

... оны ... сарын ... өдөр

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35, 69 дүгээр зүйл, Хорооны 2014 оны сарын өдрийн дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ын шаардлагыг хангаж, мэргэшлийн аттестатчилах шалгалтад тэнцсэн тул овогтой -нд /РД / чиглэлээр 20...онысарын-ны өдрөөс 20...онысарын-ны өдрийг хүртэл Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг жилийн хугацаагаар олгов.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЭРХИЙН
АТТЕСТАТЧИЛАЛД ХАМРАГДАХЫГ
ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо :

Хаана: Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мэргэшлийн зөвлөл

Засгийн газрын IV байр

Бага тойруу -6

Улаанбаатар-210646

Монгол улс

Хэнээс: овогтой.....

Регистрийн дугаар:

Миний бие үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрхийн аттестатчилалын сургалт, шалгалтад оролцохоор хүсэлт гаргаж байна.

Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад оролцохоор бичиг баримтуудыг үнэн зөв бүрдүүлж хавсаргав.

Иймд өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянаж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрхийн аттестатчилалын сургалт, шалгалтад оролцуулна уу.

Миний бие Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

ОДОО АЖИЛЛАЖ БУЙ БАЙГУУЛЛАГА /...../

АЛБАН ТУШААЛ /...../

БАЙНГА ОРШИН СУУХ ХАЯГ, УТАС

/...../

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ: /.....//...../

овог, нэр

/гарын үсэг/